



**GENCO TOUR
BUREAU JSC**

**“ЖЕНКО ТУР БЮРО” ХК
ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН
2018**

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл

Нэр: “Женко тур бюро” Хувьцаат компани

Хаяг : Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал, оффис-4

Утас: 70120202, 91961900, 94011900

Электрон хаяг: info@genco-tour.mn

1.1. Компанийн товч танилцуулга, үйл ажиллагааны чиглэл

“Женко Тур Бюро” Хувьцаат Компани нь 1997 онд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан бөгөөд аялал жуулчлалын салбарын тэргүүлэгч компаниудын нэг юм.

Эрхэм зорилго, уриа

Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох.

Бидний уриа:

Тухлах газрыг та сонго Туулах замыг бид хөтөлье

Үйл ажиллагааны чиглэл:

Манай компани нь аялал жуулчлалын үйл ажиллагааны чиглэлээр доорх үйлчилгээнүүдийг гадаад, дотоодын аялагч, жуулчдад үзүүлж байна. Үүнд:

- Дотоод, Гадаад аялал
- Дотоод, Гадаадын шууд нислэг захиалга
- Бүх төрлийн тээврийн билет захиалга
- Зочид буудлын өрөө захиалга
- Гэр жуулчны бааз
- Уламжлалт баяр наадам зохион байгуулах
- М.I.C.E Хурал, семинар зохион байгуулах

Компани нь дотоодын өндөр зэрэглэлийн 10 гаруй зочид буудал, 20 гаруй ресторан, зоогийн газар, байгалийн үзэсгэлэнт газрууд бүхий 50 гаруй жуулчны бааз, бусад үзвэр үйлчилгээ, соёл амралтын томоохон газруудтай хамтран ажиллаж байна. Мөн Ази, Европын орнуудтай, тэр дундаа, Япон, Сингапур, Солонгос, Хятад, Орос, Германы аялал жуулчлалын бизнесийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Компани нь дотоодын болон олон улсын чанартай аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт жил бүр амжилттай оролцон, жилээс жилд өөрийн гадаад харилцаагаа өргөжүүлсээр байна. Тухлах газрыг та сонго Туулах замыг бид хөтөлье

2. Компанийн менежмент, удирдлагын 2018 оны хагас жилийн тайлан

Тус компанийн удирдлага нь менежментийн бодлого, үндсэн стратегид хүрэх, улмаар эрхэм зорилгод хүрэхийн тулд 2018 онддоор дурьдсан стратегийн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

❖ Зах зээлийн стратеги зорилтууд болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа:

Уламжлалт зах зээлийг өргөжүүлж, зах зээлд эзэлж буй байр сууриа дээшлүүлэх мөн шинэ зах зээлд нэвтрэн үйл ажиллагааны хүрээгээ тэлэхийн зорилгоор тогтвортой, тасралтгүй, шинэлэг үйл ажиллагаа явуулж, аялалын шинэ бүтээгдэхүүнийг бий болгож, урамшуулал, идэвхижүүлэлт, сурталчилгааны шинэ, үр дүнтэй бодлого баримтан ажиллаж байна. Үүнд:

- Голлох зах зээлийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх
- Хятадын жуулчдыг хүлээж авах тал дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах
- Европын орнуудын зах зээлийг хөгжүүлэх
- Зүүн Өмнөд Азийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн бий болгох

❖ Харилцагч, үйлчлүүлэгчийн стратеги зорилтууд болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд:

Харилцагч түншүүдийн хувьд “Хамтын ажиллагааг эрхэмлэж, найдвартай, итгэлтэй түнш” гэсэн үндсэн бодлого баримталж доорх стратегийн зорилтуудыг хэрэгжүүлж байна.

- Тур оператор компаниудын хувьд: Гадаад орнуудын тур операторуудтай хамтран ажиллаж байна.
- Зочид буудлуудын хувьд: Аялал жуулчлалын оргил саруудад дотоодын зочид буудлуудын хүчин чадал хүрэлцээгүй болж хүндрэл үүсдэг байдлаас сэргийлэхийн тулд Баянгол зочид буудалтай байнгын хамтран ажиллах гэрээ байгуулах, зөвхөн гэрээт буудалд өөрийн жуулчдыг буулгах стратеги баримтлахаар төлөвлөж байна.
- Жуулчны баазуудын хувьд: Жуулчны баазуудтай тодорхой хөнгөлөлтийн болон давуу эрхийн гэрээ байгуулж ажиллаж байна.
- Үйлчлүүлэгчдийн хувьд “Тухлах газрыг та сонго, туулах замыг бид хөтлөе” үндсэн бодлого баримтлаж ажиллаж байна.

❖ Бүтээгдэхүүн үйлчилгээний стратегизорилтууд болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд:

Компанийн хувьд 2018 онд хэд хэдэн чиглэлээр өөрчилөн сайжруулж ажиллах стратеги зорилт баримтлаж байна. Үүнд:

Tour Operator-ын хүрээнд голлон үйл ажиллагаа явуулж аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлнэ. Үүнд:

- Үндсэн чиглэлүүдийг гарганinbound аяллын веб сайтыг шинээр бүтээх ажлыг зохион байгуулж байна.
- Өөрийн цогцолборууд дээр амарч буй зочдын сонирхолд нийцсэн төрөл бүрийн үйлчилгээнүүдийг тогтмолжуулахаар ажиллаж байна. Үүнд:

- Нүүдлийн иргэншлийн нэг өдрийн амьдралтай танилцуулах үйлчилгээ (гэр барих, буулгах, нүүдэллэх үзүүлбэр, сур элдэж хэрэглээний эдлэл хийх, эсгий хийх, цагаан идээ боловсруулах)
- Адуучдын үзүүлбэрүүд (морь уургалах, эмнэг сургах гэх мэт)
- Үндэсний урлагийн тоглолт (морин хуурын үзүүлбэр гэх мэт)
- Од ажиглуулах үйлчилгээ
- Цогцолборын отгуудаар аялуулах явган ба морин аялал
- Бусад дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлүүдийг бий болгохоор зорин ажиллаж байна.

Өөрийн цогцолборуудын үйл ажиллагаанд үйлчилгээний соёлыг дээд түвшинд хүргэхээр тодорхой төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Аялал жуулчлалын үйлчилгээний онцлогийн талаар сургалтын материал бэлтгэн цогцолборуудын ажилчдыг сурган ажиллахаар төлөвлөж байна.

❖ Борлуулалтын стратеги зорилтууд болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд:

2018 оноос эхлэн зар сурталчилгаа, борлуулалтын шинэ стратеги зорилт тавьж ажиллаж байна. Үүнд: Зар сурталчилгаа, мэдээллийн таниулах материалуудын хэв загварыг шинэчилнэ.

Зар сурталчилгаа явуулах хэлбэрийг доорх чиглэлээр нэмэгдүүлнэ. Үүнд:

- Гадаад болон дотоод жуулчдад хандсан танилцуулах материал
- Тур операторын танилцуулга
- Гадаад аялалын танилцуулга
- Цогцолборуудын танилцуулга
- Цогцолборуудынхаягийн самбар
- Цогцолборуудынорчны онцлогийг харуулсан танилцуулах самбар
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- Компанийн website
- Дотоод болон гадаадад зохиогдох үзэсгэлэн яармагт оролцох

Өрсөлдөгч байгууллагуудынхаа үйлчилгээ, бүтээгдэхүүнтэй танилцах, шинэ мэдээлэл олох, шинэ бүтээгдэхүүн бий болгох, жуулчны улирал эхлэхээс өмнө жуулчдаа үйлчлүүлэх жуулчны баазуудаар явж үзэх, шинэ маршрут нээх менежерүүдийн аялал зохион байгуулахаар мөн төлөвлөн ажиллаж байна. Зах зээлийн судалгаа явуулах, зар сурталчилгааны мэдээллийн бааз суурьтай болох, түүнд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

❖ Хүний нөөцийн стратеги зорилтууд болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд:

2018 оноос эхлэн компанийн хөдөлмөрийн бүтээмжийг боломжит дээд хэмжээнд хүргэхийн тулд дор дурьдсан стратеги зорилтуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Богино хугацаанд шинэ түвшинд хүрэхэд шаардагдах баг бүрдүүлэх
- Цогцолборуудын санхүүгийн ажиллагааг удирдан явуулах тогтолцоог боловсронгуй болгох
- Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, цалингийн урамшуулал бий болгож идэвх зүтгэлийг нь өрнүүлэх
- Цаашид үйлчилгээний соёл, зочдод үйлчлэх ур чадварын талаар ажлын байран дахь байнгын сургалт явуулна
- Ажилчдын хөдөлмөрийн бүтээмжийг боломжит дээд хэмжээнд дээшлүүлэх

- Дунд болон доод шатны менежерүүд, баазууд дээрх голлох ажилтнуудыг нарийн шалгуураар үнэлэж авах болон борлуулалттай уялдсан цалингийн сүлжээ, урамшуулалын тогтолцоог бий болгоно.

Цалингийн системийг шинэчилж, урагш дэвших, үр өгөөж өгөх шинэ санаа, санаачлага төрүүлэх урамшууллын хөшүүрэг бий болгох талаар тодорхой үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн ажил үүргүүдийн хоорондын холбоо, зохион байгуулалтын уялдааг сайжруулахаар ажиллаж байна.

❖ Удирдлагын хяналтын стратеги зорилт:

2018 онд компанийн удирдлагын зүгээс хяналтын түвшинд баримтлах стратеги зорилтуудыг доорх байдлаар тодорхойлон ажиллаж байна.

- Чадварлаг, цэгцтэй, цомхон баг бүхий зохион байгуулалтын шинэ бүтцээр зах зээлд өрсөлдөнө.
- Ур чадвар, идэвхи зүтгэлтэй ажилчдыг бүрдүүлж хөдөлмөрийн бүтээмжийг боломжит дээд хэмжээнд дээшлүүлнэ.
- Шинэчилсэн бүтцийн схемийн дагуу ажлын байруудад хийгдэх ажил үүргүүдийг нэг бүрчилэн тодорхойлно.
- Ажилчдын анкет бүртгэл, гэрээг шинэчлэн бүртгэж, ур чадварыг тогтоож, хөдөлмөрийн идэвхи, хариуцлагыг дээшлүүлнэ.
- Бүтэц зохион байгуулалтын дагуу мөрдөх дотоод журам, туслах журмуудыг боловсруулж мөрдүүлнэ.
- Компанийн санхүүгийн тогтолцоо болон санхүүгийн удирдлагын хяналтын системийг шинэчилэн сайжруулж, цогцолборууд дээр мөрдөх бүртгэлийн стандартуудыг тогтооно.

Компанийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар байнгын хяналт тогтоохоор дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхээс гадна цогцолборууд дээрх ажилтнуудын ур чадвар, жуулчдад үйлчлэх үйлчилгээний чанарыг хянах, үйл ажиллагааг сайжруулах талаарх санал авах асуулгын хуудас гарган жуулчдаар бөглүүлж, дүгнэн цаашдийн үйл ажиллагаанд хэрэгжүүлээр төлөвлөн ажиллаж байна. Үйлчилгээний соёл, чанарыг дээшлүүлэх дотоод сургалтуудыг ачааллын бус улиралд тогтмолжуулан зохион байгуулахаас гадна өөрсдийн менежерүүдийн нөөцөөр сургалтын материал бэлтгэн, үйлчилгээний соёлын сургалт явуулна.

3.Санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлт

Санхүү байдлын хураангуй тайлан /мянган.төгрөг/

Үзүүлэлт	2017-2	2017-4	2018-2
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	114,747.2	106,855.6	65,754.0
Дансны авлага	275,136.1	187,352.9	278,774.9
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,001,659.2	859,038.4	804,414.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,848,830.9	9,650,454.5	9,624,831.1
Нийт хөрөнгийн дүн	10,850,490.	10,509,492.	10,429,245.
	1	9	9
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,765,037.9	1,457,789.6	1,575,759.2
Урт хугацаат өр төлбөрийн дүн	799,449.8	661,903.1	578,030.4
Эздийн өмчийн дүн	8,286,002.4	8,389,800.2	8,275,456.3

Орлогын хураангуй тайлан /мянган төгрөг/

Үзүүлэлт	2017-2	2017-4	2018-2
Борлуулалтын орлого (цэвэр)	1,385,797.3	3,462,937.2	2,567,231.9
Борлуулалтын өртөг	1,201,445.9	3,011,613.8	2,514,226.1
Нийт ашиг (алдагдал)	184,351.4	451,323.4	53,005.8
Ерөнхий ба удирдлагын зардал	151,551.2	235,041.6	164,863.4
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	63,818.8	167,616.6	-114,343.9

4. Үйл ажиллагааны тайлан

Маркетингийн албаны тайлан

Дотоод аялал олон улсын зах зээлд: Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд албан ёсны түнш болон зочин хэлбэрээр ажилласан ба “Женко Тур Бюро” ХК энэхүү арга хэмжээнд дотоод аяллын багц бүтээгдэхүүн, гэр баазын үйлчилгээ, Чингисийн хөшөө болон XIII-зуун цогцолбор, галт тэрэг болон онгоцны билет, зочид буудал, тусгай хөтөлбөрт арга хэмжээг сурталчилан нэгдмэл сэтгүүл, брошур, видео шторк бэлтгэн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилан танилцуулсан. Сар болгон тусгай арга хэмжээ болон аяллын багцуудыг хамтран ажилладаг олон улсын аяллын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Дотоод аялал: Дотоодын аялагчидад зориулан гаргадаг аяллууд болон тусгай хөтөлбөрт арга хэмжээнд дараах маркетингийн идэвхижүүлэлтийг ашиглан ажиллаа. Үүнд авто радио 96,3FM болон 88,7 FM- ээр аялал болон тусгай хөтөлбөрт арга хэмжээг сурталчилсанболон сэтгүүл сонин, телевизийн шууд нэвтрүүлэг, видео шторк, томоохон худалдааны төвүүд болон үйлчилгээний газруудаар биечилсэн суртчилгаа, хэвлэмэл сэтгүүл брошур тараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Мөн телевизийн өргөн сувгуудтай хамтран ажиллахаас гадна, социал маркетингийн сувгийг түлхүү ашиглан зорилтот үйлчилүүлэгч нарт хүргэн ажиллаж байна.

Цогцолборууд:“Чингис хааны морьт хөшөө цогцолбор”, “XIII зуун цогцолбор”-ын борлуулалт нэмэгдүүлэх зорилгоор дотоодын аялал жуулчлалын 4 үзэсгэлэнд оролцсон мөн олон улсын 5 үзэсгэлэнд цогцолборууд болон бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилан оролцлоо. Сар болгон борлуулалт маркетинг, тусгай хөтөлбөрт арга хэмжээнүүдийг төлөвлөн зохион байгуулж ажилласан болно.

Баримтлан ажилласан маркетингийн үйл ажиллагааны стратеги:

Чанартай үйлчилгээ- “Хямд үнэтэй-шинэ сонголт” стратегийг бүтээгдэхүүн, үйлчилгээн дээр баримтлан ажилласан болно. Үүнд:

- Жуулчин илгээдэг зах зээл дэх аялалын тур операторуудтай мэдээллийн байнгын эргэх холбоотой хамтран ажилласан.
- Шинэ чиглэлд, янз бүрийн үнийн сонголттой аяллын бүтээгдэхүүн боловсруулах, хэрэглэгчидэд мэдээллийг хүргэхийг зорин ажилласан.
- Аяллын давуу талууд болох зочид буудал, үзвэр үйлчилгээний онцлогыг голлон аялал сонирхож байгаа хүмүүст дэлгэрэнгүй мэдээлэл хүргэсэн.
- Адал явдалт аялал сонирхдог аялагч нарт зориулж бүтээгдэхүүн боловсруулсан.

Өрсөлдөхүйц үнэ

- Жуулчин илгээдэг бүх зах зээлд аялалын өрсөлдөхүйц үнийн мэдээллийг түгээн ажиллах тал дээр тогтмол анхаарч ажилладаг.
- Боломжит санхүүгийн чадавхид нь тулгуурласан аялалын үйлчилгээг аль ч төвшинд бүрдүүлэн ажилласан.
- Байнгын үйлчлүүлэгч нарт зориулсан үнийн хөнгөлөлт, сүүлийн суудлын хөнгөлөлт урамшуулал, гарын бэлэг, ЖТВ бонус карт олгох зэрэг үйлчилгээг санал болгон ажилласан.

Жуулчин илгээдэг зах зээл дээрх маркетингийн дэмжлэг

- Гол зах зээлд төлөөлөгч компанитай байнгын эргэх холбоотой ажилласан.
- Тур операторуудтай хамтран зах зээлийн компанит ажил зохион байгуулж ажилласан.
- Нэмэлт үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.
- Гадаад түнш компаниудтай хамтран 3 удаагийн шууд нислэгтэй аяллыг амжилттай зохион байгуулсан.

Аяллын албаны тайлан

2018 оны эхний хагас жилийн хугацаанд гадаадруу чиглэсэн аяллын тухайд арван таван оронруу /АНЭУ, Тайланд, Япон, БНСУ, Вьетнам, Сингапур, Малайз, Орос, Хонгонг г.м /хорьгаран төрлийн аялалын хөтөлбөрөөр нийт 600 /зургаан зуун/ дотоодын жуулчдад үйлчилсэн байна. МИАТ ХК-аас 2017 оны 11 сараас эхлэн Тайланд Улсын Банконг хотруу шууд нислэг долоо хоногт 2 удаа тогтмол үйлдэх болсон хэдий ч 2018 оноос онгоцны дутагдлаас тухайн аялал тогтмол хийгдэхгүй болсон иймээс хувиарт нислэгээр группын захиалгаар аялал зохион байгуулагдсан. Тус нислэг зогссоноор 3-р сард АНЭУ-ын Дубай хот, 4-р сард Вьетнам улсын Ханой хотруу шууд нислэг МИАТ ХК-аас захиалан тус тус 36 хүний бүрэлдэхүүнтэй багц аялал амжилттай зохион байгуулсан болно. Мөн 2018 онд Женко Тур Бюро ХК-ийн брэнд аялал болсон шууд нислэгтэй Сингапур хотын аялал 200 хүний бүрэлдэхүүнтэй багц аялалыг дахин сэргээн зохион байгуулсан болно. Энэ жилийн хувьд нийт аялагчдын 60 гаруй хувь нь хувь хүн, гэр бүл байсан бол 40 гаруй хувь нь албан байгууллагын хамт олон байсан болно.

2018 оны эхний хагас буюу 1 сараас 6 сарын хугацаанд гадаад улсаас МУ-д аялах гадаадын жуулчдыг хүлээн авахтай холбоотой бэлтгэл ажлууд хийгдсэн болно. МУ-дөвлийн аялал жуулчлал хөгжөөгүйтэй холбоотой хүлээн авах жуулчид маш цөөхөн болно. Бэлтгэл ажлын хүрээнд зочид буудал, ресторан, үзвэр, гэр баазуудтай гэрээ хийх, үнийн санал гаргах, хөтөлбөрийг судлан зах зээл бүрийн жуулчдын онцлогт тохируулан шинэчлэн сайжруулах ажлууд хийгдсэн болно.

Манай компанийн голлох жуулчид Япон, Солонгос болон Сингадур улсын иргэд болно. 2018 оны жуулчдын улирлын хугацаанд 5-7 улсаас нийт 500-700 гаран жуулчид МУ-ын нутаг дэвсгэрээр 10-15 гаруй багц хөтөлбөрөөр аялах ажлыг нийт 3-5 зочид буудал, 15-20 жуулчны бааз, 20 гаруй ресторан, 40 гаран жуулчны авто тээврийн хэрэгсэл, 15 гаран мэргэжлийн хөтөч тайрбарлагчтайгаар зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн болно.

Хүний нөөцийн албаны тайлан

Компанийн Эрхэм Зорилго: Гадаад дотоодын жуулчдын эрэлт, хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүнээр, чанартай үйлчилгээг үзүүлэх, олон улсын түвшинд хүрсэн үндэсний тур оператор болох үндсэн зорилготой.

Хүний нөөцийн зорилго: Мэргэшсэн, чадварлаг нөөцийг чухалчлах, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, ажилчдын өрсөлдөх чадварыг сайжруулах, хамтын ажиллагаа, нэгдмэл байдал, багийн сэтгэлгээг эрхэмлэх.

2018 оны эхний хагас жилд захиргаа, хүний нөөцийн алба дараахь үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Хүний нөөцийн төлөвлөлт
- Бүрдүүлэлт сонгон шалгаруулалт
- Хөдөлмөрийн харилцаа

Хүний нөөцийн төлөвлөлт

Компанийн үйл ажиллагааны хэрэгцээнд үндэслэн 2018 оны хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөны дагуу үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. Байгууллагын цаашдын хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан хүний нөөцийн бүрдүүлэлтийг цогц төлөвлөгөөг боловсруулсан ба төлөвлөгөөний дагуу бүрдүүлэлтийг хийж байна. Компаны удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд ажил горилогчдын мэдээллийн сан бүрдүүлэх, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, шаардлагатай сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог боловсруулах, хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөн амжилттай хэрэгжүүлж байна.

Бүрдүүлэлт сонгон шалгаруулалт

2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 46 ажлын байр зарлагдсанаас 158 ажил горилогч ажлын сонгон шалгуурлалт, ярилцлаганд орж дараах ажлын байруудад бүрдүүлэлт хийгдсэн.

Үүнээс ажлын байраар харуулвал:

- Ерөнхий менежер-1
- Цогцолбор хариуцсан менежер -1
- Тооцооны ня-бо -2
- Аяллын мэргэжилтэн -4
- Захиалгын ажилтан -1
- ЧМХЦ-т Үйлчилгээний менежер -1
- ЧМХЦ-т Үйлчилгээний ажилтан -2
- ЧТХЦ-т Гэр баазын үйлчилгээний ажилтнууд-5
- ЧМХЦ-т Тогооч-4
- ЧМХЦ-т бэлтгэгч, угаагч -3
- ЧМХЦ-т Зөөгч -2
- ЧМХЦ-т үйлчлэгч -2
- 13-р зуун – Гэр баазын үйлчилгээний ажилтан -4
- 13-р зуун - Туслах ажилтнууд -3
- 13-р зуун – Туслах малчин-2
- Үйлчилгээний жолооч- 2

Хөдөлмөрийн харилцаа

2018 оны хагас жилийн байдлаар мөн улирлын ажлын ачаалалаас шалтгаалан 39 гэрээт ажилчидыг ажлын байраар хангаж хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж байна. Компаний хөдөлмөрийн харьцааны зохицуулалтын хүрээнд компани үйл ажиллагааны дотоод журмыг шинчилэн боловсруулах, цогцолборуудын хөдөлмөрийн харьцааг зохицуулах дотоод дүрэм журмыг шинэчлэн боловсруулах, цалин хөлс, урамшуулалын тогтолцоог боловсронгуй болгох, гол ажлын байрнуудад ажилагсадыг тогтвортой ажиллуулах хөшүүргийг бий болгох зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Компанийн хүний нөөцийн бусад үйл ажиллагаа

ЧМХЦ-д согтууруулах ундааны зөвшөөрлийг сунгасан бабусад холбогдох гэрээ болон зөвшөөрлүүдийн хугацааг хянасан ба цахилгаан ашиглалтын зардлыг бууруулж шинэчлэсэн гэрээ байгуулан ажиллаж байна. Компаниас нийт 112 дугаар бүхий албан тоот боловсруулсан. Мөн томоохон үйл ажиллагаа зохион байгуулдагтай холбоотойгоор даатгалын гэрээ байгуулан ажилласан. Компанийн хэмжээнд оффисын тавилга шинэчлэсэн ба уулзалтын өрөөг шинэчлэн тохижуулсан. Цогцолборуудын ажилчдыгэрүүл мэндийн үзлэгт хамруулсан. ЧХМХ, 13 дугаар зуун цогцолборын ажилтнуудын ажлын хувцасыг шинэчлэсэн.

Чингисийн морьт хөшөө, 13-р зуун цогцолборын тайлан

Цогцолборуудын тохижилт, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар

Дотоодын хөрөнгө оруулалтаар бүтээн босголт хийсэн ЧХМХ, 13-р зуун цогцолборууд жил бүр тодорхой тохижилт, зарим тохиолдолд барилга угсаралтын ажилууд хийгдэх шаардлага зүй ёсоор урган гардаг. Иймээс тус компани нь тухайн жил бүр үйлчилгээний чанар стандартыг барьж ажиллахын тулд 2018 онд мөн тохижилт, техник угсаралтын ажлуудыг төлөвлөн дараахь үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

ЧХМХ Цогцолборт

- Өндөр хүчдлийн цахилгааны урсгал засвар
- Цогцолборын бүрэн хяналтын камержуулалт
- Гэр баазын усан хангамжийн худгийн насосын засвар үйлчилгээ
- Гэр баазын сантехникийн засвар

13-р зуун цогцолборт

- Нарны эрчим хүчний суурьлуулалт
- 00 болон душийн сантехникийн угсаралт

Дээрх техникийн ажлууд хийгдсэнээр ЧХМХ Цогцолборын өндөр хүчдлийн салбар шугамын техникийн асуудал бүрэн шийдэгдсэн. Хяналтын камерийн угсаралтын асуудлыг бүрэн шийдсэн нь үйл ажиллагааны хяналт болон аюулгүй байдлыг эрс сайжруулсан. Гэр баазын усан хангамжийн доголдолыг арилган худгийн насосыг шинээр сольсон нь жуулчдын тав тухтай байдлыг хангахад дорвитой арга хэмжээ боллоо. 13-р зуун цогцолборт хийгдсэн техникийн ажлууд нь мөн жуулчдын тав тухтай байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа боллоо.

Үйлчилгээний төрөл, борлуулалтыг нэмэгдүүлэх талаар

Энэхүү зорилтын хүрээнд ЧХМХ Цогцолборт хоёр төрлийн музейг байршуулан үйлчилгээний түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Чингис хааны түүхтэй холбоотой лааны тосон баримлын музей
- Монголчуудын амьдрал уламжлалыг харуулсан угсаатны зүйн музей

Түүнчлэн Монголын уламжлал, ёс заншилтай холбоотой бэлэг дурсгалын хэрэгцээг үндэслэн шинээр түрээслэгчдийг нэмэн цогцолборт жуулчдад зориулсан дэлгүүрүүдийн тоог нэмэн ажиллаж байна.

Борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгооруламжлалт эвэнт арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Үүнд

- Хүннү Музик Фестивал
- Чингисийн үр сад хүүхдүүдэд зориулсан үйл ажиллагаа
- Наадмын арга хэмжээ /13-р зуун цогцолборт/
- Бид хамтдаа хөтөлбөр

Эдгээр арга хэмжээнүүдийн нь үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчилгээний төрлийг олшруулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. 13-р зуун цогцолбор нь алслагдсан, цахилгааны бүрэн хангамжгүй байдгаас зарим тохиолдолд төвөөс ирсэн аялагчдад банкны картаар үйлчилүүлэх боломж хязгаарлагдмал байдаг ба энэхүү асуудлыг шийдэхээр тодорхой үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж байна.

5. Удирдлагын талаарх мэдээлэл


Гүйцэтгэх удирдлага

№	Нэрс	Албан тушаал
1	Цэнд Энхсайхан	Гүйцэтгэх захирал
2	Б.Түмэндэмбэрэл	Ерөнхий нягтлан бодогч

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичиг

№	Нэрс	Албан тушаал	Компанид хувьцаа эзэмшдэг эсэх
1	Данзан Даянбилгүүн	ТУЗ-ийн дарга	-
2	Бүрэнмэнд Лхагвадорж	ТУЗ-ийн ердийн гишүүн	-
3	Баттулга Намуун	ТУЗ-ийн ердийн гишүүн	4.3
4	Дашцэрэн Даваасүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн	8.56
5	Халтмаа Цэндбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн	-
6	Б.Мянганбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн	-
7	Цэнд Энхтуяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
8	Балжинням Амарсанаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
9	Тэгшээ Одням	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
10	Даваасамбуу Шүрэнцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	-

5 хувиас дээш хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл



ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан

“Женко тур бюро” ХК-ийн 2018 оны 04 сарын 27 ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж хурлаас одоогийн ТУЗ-ийн гишүүд сонгогдон ажилласан. Шинээр томилогдсон ТУЗ-нь хуралдан ТУЗ-ийн даргаар Д.Даянбилгүүн-г 100 хувийн саналаар сонгосон. Мөн дараах байдлаар ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг томилсон.

№	Хороод	Гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Нэр дэвшүүлэх хороо	Б.Амарсанаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
		Ц.Энхтуяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
		Б.Мянганбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн
2	Аудитын хороо	Д.Даваасүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн
		Б.Амарсанаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
		Т.Одням	ТУЗ-ийн хараат бус гишүүн
3	Цалин урамшууллын хороо	Б.Намуун	ТУЗ-ийн ердийн гишүүн
		Б.Амарсанаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
		Т.Одням	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Байгууллагын нэр : Женкотур бюро

Байгууллагын регистр : 2108011

2018 оны 2 улирлын тайлан

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	106,855.6	65,754
1.1.2	Дансны авлага	187,352.9	278,774.9
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	8,441.5	2,981.2
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	332,189.3	223,729.6
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	224,199.1	233,175.1
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	859,038.4	804,414.8
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,276,118.5	9,035,761.6
1.2.2	Биет бус хөрөнгө	511,126.4	476,969.5
1.2.3	Биологийн хөрөнгө		112,100
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,863,209.6	
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,650,454.5	9,624,831.1
1.3	Нийт хөрөнгийн дүн	10,509,492.9	10,429,245.9
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	617,965.4	710,078.6
2.1.1.2	Цалингийн өглөг	1,043.7	15,907.9
2.1.1.3	Татварын өр	336,355.1	380,010.8
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	296,245.8	263,582.3
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	206,179.6	206,179.6
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,457,789.6	1,575,759.2
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл	661,903.1	578,030.4
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	661,903.1	578,030.4
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,119,692.7	2,153,789.6
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч	7,998,880.2	7,998,880.2
2.3.1	-төрийн		
2.3.2	-хувийн	7,998,880.2	7,998,880.2

2.3.3	-хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	209,680.2	209,680.2
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	706,061.1	706,061.1
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-524,821.3	-639,165.2
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	8,389,800.2	8,275,456.3
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	10,509,492.9	10,429,245.9

Захирал /Б.Намуун/

Нягтлан бодогч /null/

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,462,937.2	2,567,231.9
2	Борлуулалтын өртөг	3,011,613.8	2,514,226.1
3	Нийт ашиг (алдагдал)	451,323.4	53,005.8
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	890	109
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	235,041.6	164,863.4
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	48,828.9	5,820.1
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	20,610.8	3,224.8
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	188,953.7	-114,343.9
19	Орлогын татварын зардал	21,337.1	
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	167,616.6	-114,343.9
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	167,616.6	-114,343.9
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	167,616.6	-114,343.9
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Захирал /Б.Намуун/

Нягтлан бодогч /null/

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувицаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	7,998,880.2		209,680.2	706,061.1			-692,437.9	8,222,183.6
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
2	Залруулсан үлдэгдэл	7,998,880.2		209,680.2	706,061.1			-692,437.9	8,222,183.6
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							167,616.6	167,616.6
4	Бусад дэлгэрэнгүй орлого								
5	Өмчид гарсан өөрчлөлт								
6	Зарласан ногдол ашиг								
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	7,998,880.2		209,680.2	706,061.1			-524,821.3	8,389,800.2
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
2	Залруулсан үлдэгдэл	7,998,880.2		209,680.2	706,061.1			-524,821.3	8,389,800.2
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							-114,343.9	-114,343.9
4	Бусад дэлгэрэнгүй орлого								
5	Өмчид гарсан өөрчлөлт								
6	Зарласан ногдол ашиг								
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	7,998,880.2		209,680.2	706,061.1			-639,165.2	8,275,456.3

Захирал /Б.Намуун/

Нягтлан бодогч /null/

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	3,545,106.4	2,539,253.3
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,545,106.4	2,539,253.3
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн	3,070,109.9	2,379,327.8
1.2.1	Ажиллагчдад төлсөн	386,799.5	191,295.6
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	145,741	16,000
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,587,388.8	2,100,280.1
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	107,216.2	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,070.1	2,838.7
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	192,520.3	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	186,749.6	32,806.6
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	431,624.4	36,106.8
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	474,996.5	159,925.5
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	890	109
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	890	109
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн	28,108.9	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,108.9	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-27,218.9	109
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	6,215.7	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4		6,215.7	
3.2	Мөнгөн зарлагын дүн	357,874.7	201,569.7
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	354,052.7	201,569.7
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5		3,822	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-351,659	-201,569.7
4	Валютын ханшийн зөрүү		433.6
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	96,118.6	-41,101.6
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	10,737	106,855.6
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	106,855.6	65,754

Захирал /Б.Намуун/

Нягтлан бодогч /null/

